



ГАЛТ ТЭРЭГНИЙ
ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН
НЭГДСЭН ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Төмөр замын тээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Засгийн газрын 2020 оны "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.6.1.3.3, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" А/19 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд туссан Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөний 3.6.1.3.3, "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүгд Найрамдах Солонгос Улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-тай хамтран хэрэгжүүлэх "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн барилга барих, үйл ажиллагааг чадавхжуулах замаар Монгол Улсын төмөр замын тээврийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх төсөл", (Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын барилга барих төсөл)-ийн бэлтгэл ажлыг хангах, төслийг үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ажлын
хэсгийн
ахлагч:

Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт, судалгааны
хэлтсийн дарга

Салбарын судалгаа, олон нийтийн харилцаа хариуцсан
мэргэжилтэн

Салбарын судалгаа, хамтын ажиллагааны мэргэжилтэн

Технологи, автоматжуулалт, судалгаа, хариуцсан ахлах
мэргэжилтэн

Олон улсын болон дотоодын төслийн мэргэжилтэн

Технологи, автоматжуулалт, судалгааны мэргэжилтэн

Гишүүд:


Тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын ахлах
мэргэжилтэн

Галт тэрэгний хөдөлгөөн, зурмаг зохицуулалтын
мэргэжилтэн

Ашиглалтын ажлын техникийн нормчлол, арга зүйн
мэргэжилтэн

000817

“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв”
улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын 2021 оны
5-дугаар сарын 20-ны өдрийн 183 дугаар тушаалын
хавсралт



“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн барилга барих, үйл ажиллагааг чадавхжуулах замаар Монгол улсын төмөр замын тээврийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх төсөл”-ийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийн удирдамж

Нэг. Ажлын хэсгийн зорилго:

Бүгд Найрамдах Солонгос Улсын “Солонгосын олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлэх “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн барилга барих, үйл ажиллагааг чадавхжуулах замаар Монгол улсын төмөр замын тээврийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх төсөл”-ийн хэлэлцээрийн проколд тусгагдсан ажлын хэрэгжилтийг хангаж, бэлтгэл ажлыг зохион байгуулахад тус ажлын хэсгийн зорилго оршино:

Хоёр: Ажлын хэсгийн ажлын тайлан гаргах хугацаа:

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвөөс байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн сар бүрийн 15, 25-нд төслийн бэлтгэл ажлын хэрэгжилтийг тайлагнах, Төсөлтөй холбоотой төлөвлөгөө, тайлан, тушаал, шийдвэр, гэрээ, албан бичиг, орчуулгын материал зэрэг холбогдох түвшний бичиг баримтын бүрдлийг цахим орчинд байршуулж, төслийн ил тод байдлыг ханган ажиллах.

Гурав: Ажлын хэсгийн бэлтгэл ажил

3.1 Ажлын хэсгийн гишүүдийн ажиллах хуваарь, гүйцэтгэх ажлын чиглэлийн талаар нарийвчилсан төлөвлөгөө, хуваарийг гаргаж, батлуулан мөрдөж ажиллах,

3.2 Төслийн бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг гаргах батлуулах,

3.3 Батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу шаардагдах зөвшөөрөл шийдвэрийг гаргуулах,

3.4 Батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу төсөвт өртгийг тооцох, шийдвэрлүүлэх

3.5 Батлагдсан ажлын төлөвлөгөөний ажлуудын эрхзүйн орчны судалгаа хийх, гарч болох эрсдэлийг тодорхойлох, бууруулах арга хэмжээ авах

3.6 Батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу ажлын хэсгийн гишүүн бүр 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөт ажилтай харилцан ачаалал үүсгэхгүйгээр хувийн зохион байгуулалтыг сайжруулж ажиллах.

3.7 Ажлын хэсэг төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс төвийн хэмжээнд төсөл хэрэгжүүлэх журам боловсруулан, мөрдлөг болгон ажиллах

Дөрөв: Ажлын хэсгийн ажлын чиглэл

Д/д		Хариуцагч	Баг	Хариуцах ажил	Төслийн төлөвлөлт урьдчилсан байдлаар																	
1		Д.Төгсжаргал	Хэлтсийн дарга	Ажлын хэсгийг үр ашигтай зохион байгуулж, удирдлага арга зүйгээр хангах	2021			2022			2023			2024			2025			2026		
					1У	2У	3У	4У	1У	2У	3У	4У	1У	2У	3У	4У	1У	2У	3У	4У		
2	3	Э. Энхцэцэг Г.Билгүүн		Төслийн А.Мастер төлөвлөгөөг боловсруулахад БНСУ-ын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, бэлтгэл ажлыг хангах, холбогдох материалгаар ханган ажиллах, орчуулгын ажил хийж гүйцэтгэх																		
4		Д.Лхагваа	I баг																			
5	6	Г.Өлзийсайхан З.Мөнхтуяа	II баг	Д. Дадлагажих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэн ажиллах; төслийн А,В,С,Е ажлуудад дэмжлэг үзүүлэх холбогдох бичиг баримтын бүрдэлд хяналт тавих, хөтлөх, бүтргэх, боловсруулах, олон нийтэд сурталчилан таниулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.																		
7		Д.Амарзаяа																				
8	9	Г.Чангас Т.Мейрамбек	III баг	Төслийн А. Мастер төлөвлөгөө боловсруулах, В Туршилтын систем хөгжүүлэх, БНСУ-ын мэргэжтнүүдтэй хамтран ажиллах, бэлтгэл ажлын хэрэгжилтийг хангах.																		
10		О.Оюунболд		Төслийг үр дүнтэй зохион багуулах, багууд хоорондын харилцан уялдааг хангах үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх, С. ГТХЗНТ-ийн барилга угсралтын ажлын хэрэгжилтийг ханган ажиллах.																		
11		Г. Баттөр	IV баг	Төслийн А,Б ажил болон төслийн хугацаанд болон төслийн дараах																		
					Хэрэгжүүлэлт																	
					Бэлтгэл ажил																	

			<p>тогтвортой байдлыг хангахад техник технологи, програм хангамжийн тасралтгүй ажиллагааг хангах бодлого судалгааг боловсруулан ажиллах.</p>
12	С. Золзаяа		<p>Төслийн хүрээнд хийгдэх A,B,C,D,E зорилтуудын төсөл хүлээн авагч талын хариуцах ажлуудын төсөвт өртөг, холбогдох үйл ажиллагааг зохион байгуулах, зөвшөөрөл авах, төслөөр ирэх бараа материалыг гааль, татвараас чөлөөлөх, бараа материалын татан авалт хийх ажлыг хэрэгжүүлж ажиллах.</p>
13	М.Оюун-Ундрэм	VI баг	
14	Д. Пүрэвдолгор		
15	Д.Дарьсүрэн	VII баг	<p>С.ГТХЗНТ-ийн төвийн барилын угсралтын ажлын бэлтгэл ажлыг зохион байгуулах. Холбогдох зөвшөөрлийг авах, бичиг баримтын бүрдлийг бий болгох.</p>
16	Б.Жавзандулам	IV баг	<p>Төслийн орчуулга, ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж ажиллах</p>
17	М.Үүрийнтуяа		<p>Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах эрх зүйн асуудалд хяналт тавих, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлж ажиллах.</p>